

Нэмэлт хувьцааны үнэ тогтоосон үндэслэл

Монголын Хөрөнгийн Биржийн 2010 оны 8 сарын 25-ны өдрийн мэдээгээр “Нако түлш” ХК-ийн сүүлийн 6 сарын дундаж ханш 229 төгрөг байгааг үндэслэн Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 4-т *нийтэд худалдагдаж байгаа хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо Хөрөнгийн биржийн албан ёсны мэдээнд тусгагдсан арилжааны сүүлийн 6 сарын дундаж ханшийг харгалзан тогтооно* гэж заасны дагуу 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн СЗХ –ны 235 тоот тогтоол, “Нако түлш” ХК-ийн 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн ТУЗ-ын 1 тоот тогтоолоор тэргүүн ээлжинд худалдах авах эрхээ хэрэгжүүлэх үнэ, нийтэд нээлттэй худалдагдах хувьцааны нэг бүрийн үнийг **229** төгрөгөөр тогтоож байна.

Нэмэлт хувьцааны задаргаа:

Нэмэлт хувьцааны задаргаа	Үнийн дүн	Хувьцааны тоо
Нэмэлт хувьцааны нэг бүрийн худалдах үнэ	229₮	
Нэмэлт хувьцааны санхүүжилт	370,000,109₮	
Нэмэлт хувьцааны нийт тоо ширхэг		1,615,721
Олон нийтэд санал болгож буй хувьцаа	270,264,655₮	1,180,195
Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу /хувьцаанд хөрвөх/	99,735,454₮	435,526

Санамж: Хувьцаа эзэмшигч нэг бүр нь 229 төгрөгийн үнэ бүхий нийтэд санал болгож буй 1,180,195 ширхэг хувьцаа, хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу хувьцаанд хөрвөж буй 435,526 ширхэг хувьцаанаас өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжин худалдан авах эрхтэй.

Хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж буй хувьцааны 14,68%-тай тэнцэх хэмжээний хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг олгож байна.